

XV ЗУУНЫ ҮЕИЙН МОНГОЛ ДАХЬ ЧИНГИС ХААНЫ ТАЙЛГА ТАХИЛГЫН ТҮҮХИЙГ ШИНЖЛЭХ НЬ

МЯНГАД ЭРДЭНЭБААТАР

Товч агуулга: Монголчууд Чингис хаанаа тахих явдал бол Чингис хааныг тэнгэрт хальсан тэр цаг үеэс эхэлсэн юм. Гэвч эрт үеийн Чингис хааны тахилгын тухай мэдээ сурвалж бичигт тэмдэглэгдэн үлдсэн нь ховор байдаг. Тус огүүлэл нь “Богд Чингис хааны тахилын судар” хэмээх түүхийн ховор сурвалжийг ашиглаж, XV зууны үеийн Монголын түүхэн дэх Чингис хааны тахилгыг судлаж бичив. Үүнд, Цахар түмний хийж байсан Чингис хааны тахилга нь зовхон Цахар Монголын тахилга тодий байсан биш, үнэндээ тэр нь Халх түмнийг багтаасан тэр үеийн нийт Монголын тахилга байсан бөгөөд Чингис хааны тахилгад тухайн үеийн Монголын Их хаан биечлэн оролцож байжээ.

Түлхүүр үг: Чингис хаан, тахилга, Цахар, Халх

Нэг. Түүхэн дэх “Гэрийн ноён”-ы эрхэлсэн Чингис хааны тайлга тахилга
Монголчууд Чингис хаанаа тайж тахих үйл ажиллагаа нь Чингис хааныг тэнгэрт хальсан тэр цаг үеэс эхэлсэн байдаг. Жишээлбэл, Монголын түүхийн чухал сурвалж бичиг болох “Судрын чуулган”-д энэ тухай тэмдэглэхдээ 1227 онд Чингис хааныг тэнгэрт хальсны дараахан, Чингис хааны дөрвөн их ордны, орд тус болгонд Чингис хааныг одөржин гашуудаж, гашуудлын мэдээг сонссон хол ойрын ван ноёд олон одрөөр дөрвөн зүгээс хүрэлцэн ирж Чингис хааныг тайж тахисан бөгөөд зарим аймаг бүлэгийнхэн хол байсан тул бараг гурван сар өнгөрсний дараа хүрэлцэн ирж Чингис хааныг гашуудан тахисан байжээ.¹ Түүнээс хойш монголчуудын Чингисийг тайж тахих үйл ажиллагаа нь Өгөөдэй хааны төр барьж байсан үед (1229-1241) төрийн тайлга тахилгын үйл ажиллагаа болон хувирсан бөгөөд хожим нь Хубилай хааны үе болоход Чингис хааныг дурсаж тахих “Дөрвөн цагийн хурим” гэх дөрвөн улирлын их тахилга тайлгын үйл ажиллагаа нь улмаар дүрэмжиж, Чингис хааны тахилга нь “Монголчуудын оюуны соёлын түүхийн

¹ 【波斯】拉施特主编，余大钧、周建奇汉译《史集》第一卷第二分册，北京：商务印书馆1983年，第一版第323页。

гурван их систем”²-ийн доторхи нэгэн их систем нь болсон билээ. Тэрчлэн XVI зуунаас хойшхи Чингис хааны тайлга тахилгын соёл нь бурханы шашны соёлын нөлөөг их хүртсэн³ бөгөөд монголчууд Чингис хааныг сахиусчлан шүтэж Чингис хааныг “Тэнгэрийн хөвгүүн” мөртлөө бас бурханы шашны сахиусын нэгэн болгож “Давхар сахиусчлагдсан дүр”⁴-тэй болсон байдаг юм.

XVI зуунаас өмнөх үеийн монголчуудын Чингис хааны тайлга тахилгын үйл ажиллагааг нарийн тэмдэглэсэн чухал нэгэн Монгол сурвалж бичиг гэвэл “Богд Чингис хааны тахилын судар оришвой” гэдэг хулсан үзгээр бичсэн чухал түүхийн материал байдаг. Энэхүү ховор “Тахилын судар”-ыг 1958 онд Дорунга авгай Өвөр монголын Дархан Муумянган холбоот хошууны Хавт Хасарын сүлд онгоны тахил цомцог болох “Тайл богдын ордон” байх хар шоронгийн хадан агуйгаас олсон байдаг. Тэгээд XX зууны жараад оны эхээр “Тахилын судрыг” одоогийн шинэ цагийн Монгол хэлэнд буулган хэвлээд бэлтгэж байтал “Соёлын их хувьсгал” гэх улс төрийн үймээн үүссэнээс болж хэвлэлийн ажил хагас дутуу явагдаад зогсчээ. Тийнхүү “Тахилын судар”-ыг илээр хэвлэх ажил 40 жилийн цаг хугацаагаар хойшлогдож Дорунга авгайн “Чингис хааны тахилын судар оришвой” хэмээх ховор чухал номыг 1998 онд сая нэг хэвлэжээ.⁵ Яриангүй энэхүү “Тахилын судар” хэвлэгдэхээс нь өмнө ба хэвлэгдсний дараа ч гэсэн түүний эх бичиг нь Өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд хадаглагдаж байсан тул Н.Хурц тэр материалыг ашиглан огүүлэл бичсэн байдаг⁶ бөгөөд 1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхээр Итали улсын монголч эрдэмтэн Elisabetta Chiodo “Тахилын судар”-ын тухай нарийн судлан шинжилж, хэсэг агуулгыг нь англи хэлэнд орчуулаад, тайлбар зүүлттэйгээр хоёр огүүлэл нийтлэсэн байдаг юм.⁷ Үүнээс гадна миний бие 2006 оны үед Японы Токиогийн

² “Монголчуудын оюуны соёлын түүхийн гурван их систем”-ийн онолыг миний бие 2001 онд Японд нийтлэсэн “Лигдэн хаан хийгээд Монголын бурханы шашин” гэсэн өгүүлэлдээ анх дурьдсан бөгөөд 2003 онд Японд докторын зэрэг хамгаалсан диссертаци-д дэлгэрэнгүй өгүүлсэн юм.

³ Энэ талаар дараах өгүүллээс лавлана уу. Мянгад Эрдэнэбаатар. “Их хааныг бурхны шашны сахиус болгосон асуудалд”, *MONGOLIA: Area and Culture Studies* Vol.1 (368). 2012, 173-178.

⁴ Мянгад Эрдэнэбаатар, “Чингис хааны тахилгын давхар сахиусчлагдсан шинж чанар”, *Чингис хаан судлал сэтгүүл*-ийн 2010 оны 2 дугаар хугацаа.

⁵ Дорунга (ред.). *Богд Чингис хааны тахилын судар оришвой-Монгол хууч түүхэн номын баглаа*, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1998.

⁶ N.胡尔查: 《四季祭祀的贡赋及其社会经济基础》(Dörben cay-un qurim-un alba kiged tegün-ü neyigemaju aqui-yin sayuri), 《内蒙古社会科学》蒙文版, 1988年第4期。

⁷ Elisabetta Chiodo. “The Book of the Offerings to the Holy Cinggis QaGan: A Mongolian Ritual text” in *Zentralasiatische studien* No.22, 1989/1991, 190-220; Elisabetta Chiodo. “The Book of the Offerings to the Holy Chinggis QaGan: A Mongolian Ritual text (Part 2)” in *Zentralasiatische studien* No.23, 1992/1993, 84-119.

Гадаад судлалын их сургууль болон Тайшо их сургуульд багшаар ажиллаж байсан болохоор, мөн тэр оны зун Японы Токиогоос Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод хүрч, Их Монгол улс байгуулагдсан 800 жилийн ойд зориулсан монголч эрдэмтний их хуралд оролцохдоо “Богд Чингис хааны тахилын судар”-ыг англи хэлээр танилцуулсан бөгөөд тэр өгүүлэл 2008 онд Олон улсын Монгол судлалын холбооны сэтгүүлд нийтлэгдсэн юм.⁸

Ер нь монгол бичгээр бичигдсэн “Богд Чингис хааны тахилын судар”-ын агуулгыг товчоор хэлбэл, “Цагаан түүх”-д гардаг Чингис хааныг дурсан тахих “Дөрвөн цагийн хурим” гэдэг дөрвөн улирлын их тайлга тахилгын бүх явцын тухай нарийн тэмдэглэсэн байдаг. Гэвч уул судрын сүүлчийн хэсэг нь их балархай мөртлөө уранхай тамтаг болсон тул, тус өгүүлэлд судрын эхний хэсгийн тодорхой байгаа зуны их тахилга болон намрын их тахилгын тухай тэмдэглэлийг гол болгон шинжлэн өгүүлсэн юм.

Юуны урьд “Богд Чингис хааны тахилын судар”-ын тэмдэглэлийг үндэслэвэл, “Найман отог Цахар түмэн” гэж олон удаа гардаг бөгөөд Чингис хааны тайлга тахилгад Монголын их хаан биеэр морилон саатаж, тайлга тахилгын ёслолыг өөрийн биеэр биечлэн гүйцэтгэж байжээ. Жишээлбэл, “тахилын судар”-ын хоёрдугаар хуудасны доор нь тэмдэглэхдээ “Хаан өөд болж хүрч ирэхүй дор , гэрүүн (Гэрийн) ноён морин дээр угтаж зулын архи ав” гэжээ. Үүнээс үзвэл Чингис хааны тайлга тахилгад морилон ирэх их хааныг “Гэрийн ноён” хэмээгч түшмэл морин дээр угтан авч, их хааны тайлга тахилгад өргөх “Зулын архи”-ийг хүлээн авдаг байв. Гэрийн ноён их хаанаас зулын архийг хүлээн авсны дараа тэрхүү архи сархадыг Чингис хааны тайлга тахилгын ямар ордод хэрхэн хэрэглэх тухай, “Тахилын судар”-ын дөрөв, тавдугаар хуудсанд тодорхой бичжээ. Дандаа тэмдэглэхдээ “Тэр сархадаас цацалын аяганд хийж авч сархаднаас дотор ордын зүүн өмнө тавь. Хөрөнгөнөөс уураг гарахыг өмнө тавь . Хааны хөрөнгийг ордны зүүнтээ тавь. Тэр хоёр хөрөнгийг хөрөнгөч хүн болж буй. Шүүс тавихад гэрүүн (Гэрийн) ноёд манлайд арчуул цагуу (Хоёр хос хундага) хоёрыг бариул. Шүүс тавиад гэрийн ноёд хаанд айлтга. Хаан суугаад мөргө. Цагаан сүргийн хөрөнгөнөөс цацалын аяганд хийж гэрийн ноёнд барь. Тэнгэрт цацахад хаан суудал залгаад мөргө. Өчигч хүн цацал цацаж өчиг өч.хаан гэрийн ноён хоёр эчиж шүүсийг ордын өмнө тавь. Тэр шүүс лүгээ алтан цөгцийг хаан авч ордын доторхи алтан ширээн дээр тавь” гэх мэтээр маш нарийн бичжээ. Үүнээс үзвэл

⁸ Erdenebaatar, M. “A Study on the Ritual Scripture of the Holy Cinggis QaGan” in *Mongolica* Vol.21 (42), 2008, 349-355.

Чингис хааны тайлга тахилгад тусгайлан авчирсан их хааны зулын архи сархадыг “Дотор ордод” өргөж, шүүс тавих үед, гэрийн ноён их хаанд айлтгахад их хаан биеэрээн мөргөлийн ёс хийж, алтан цөгцийг шүүстэй хамт тахилгын цомцог ордын доторхи алтан ширээн дээр өргөл барьдаг байжээ. Түүний дараа цагууд дунд хэртэй сархад хийж өргөж мөргөөд, дараа нь цагууг дүүргэж “Их Монгол” гэх дууг эхлэн дуулахад их хаан цагууг (хоёр хос худлага) авч эцгэд цомцог ордны доторхи алтан ширээн дээр гурвантаа өргөөд тавьдаг. Эдгээр тайлга тахилгын үйл ажилагаанаас үзвэл эрт үеийн Чингис хааны тахилагад “Их Монгол” гэх магтаал дууг дуулж байсан байна. Харин тун сонирхолтой нэгэн зүйл гэвэл XX зууны Ордосын Монголд явагдаж байсан Чингис хааны тайлга тахилгын ёслол дээр ч хүмүүс “Их Монгол” гэх дууг дуулж байсан гэж Сайнжаргал, Шаралдай нар “Алтан ордны тайлга” гэх алдарт номондоо тодорхой тэмдэглэсэн байдаг.⁹

Хоёр. “Богд Чингис хааны тахилын судар”-т тэмдэглэсэн Чингис хааны тайлга тахилгыг эрхэлж явуулдаг албан тушаалтны тухай гэвэл “Гэрийн ноён”, “Манлай”, “Таваг тавигч”, “Ширбичин”, “Царгичин” зэргийн нэрс гардаг боловч “Жонон” ямданы тухай харин ер дурдсангүй байна. Тэрчлэн “Гэрийн ноён” хэмээгч ямданы тайлга тахилгын бүх үйл ажиллагааг ерөнхийлөн захирч, эрхлэн явагдуулж байсныг “Тахилын сударт” тэмдэглэжээ. Судлаач нарын судалгааны бүтээлийг үндэслэвэл Чингис хааны “Найман цагаан орд” бүрэлдэх явцад дөчин нэр “Гэрийн ноён” гэх тусгай ямдантай байжээ.¹⁰ Сүүлээр тэр нь аажмаар солигдон “Жонон”-гоор тэргүүнээ болгосон “Найман их ямдан” болон бүрэлджээ.¹¹ Ордост явагддаг Чингис хааны тайлга тахилгыг “Жонон” ерөнхийлөн хариуцаж байсан юм. Үнэнийг хэлвэл “Жонон” гэдэг үг бол “晋王” гэх Хятад нэр үгнээс авиа хувирч ирсэн бөгөөд Юань улсын үед их хаан Дайду хот буюу Шанд хотод суудаг байсан бол харин Жонон уугуул Монгол путагтаа Чингис хааны дөрвөн их ордыг сахин сууж байжээ.¹² Үүгээс гадна Өвөр Монголын багшийн их сургуулийн Насан-Өлзий профессорын нийтэлсэн Цахар түмний бүрэлдэлийн тухай эрдэм шинжилгээний өгүүллийг үндэслэвэл: Монголын их хааны төвлөн суусан “Цахарт явагдаж байсан Монголын хаант төрийн тэнгэр газрын тахилгын тогтоол” бол умард Юаны үе 1368 оноос 1438 оны хооронд бичигдэж, тэрчлэн бас

⁹ Сайнжаргал, Шаралдай. *Алтан ордны тайлга*. Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо, 1983 (анхдугаар хэвлэл), 165.

¹⁰ Chiodo (1989/1991), 202.

¹¹ Сайнжаргал, Шаралдай. *Алтан ордны тайлга*. Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо, 1983 (анхны хэвлэл), 432-436.

¹² 乌 兰: 《蒙古源流研究》, 沈阳: 辽宁民族出版社, 2000年, 318-319页.

“1438 оноос хойш тухайлбал Эсэн хааны цаг үед, Монголын их хаан ба Жонон хоёр Монголын зүүн, баруун жигүүрийг хуваан захирах улс төрийн байгуулал хийгээд зургаан түмэн хэмээгч эхлэн бүрэлдэж, тус зургаан түмний нэг болох Цахар түмэн ч энэ үед бүрэлдсэн байдаг”¹³ гэжээ. Энэ мэтээр Даян хаанаас Монголын зургаан түмнийг нэгтгэхээс өмнө хэдийгээр “Жонон” гэх ямдан байсан боловч тэд зөвхөн Чингис хааны дорвон ордыг сахиж сууснаас биш, Чингис хааны пайман цагаан орд дахь тайлга тахилгын ажиллагааг шууд захирч байсан эсэхийн тухай тодорхой түүхийн баримт олдохгүй байна. Учир нь Даян хаан 1510 онд “Далан тэргүүний байлдаан”-аар сая Монголын баруун гарын гурван түмнийг эрхлээлдээ оруулж, өөрийн гуравдугаар хүү болох Барсболд сайналагийг баруун гурван түмнийг ерөнхийлөн захирах “Жонон”-гоор томилсон байв.¹⁴ Тэгээд сая Барсболд нь Даян хаан Монголыг дахин нэгтгэсний дараах анхны “Жонон” болж, Чингис хааны найман цагаан ордыг шууд захирдаг “Жонон” болсон билээ. Гэвч “Богд Чингис хааны тахилын судар”-т “Жонон” гэх ямдан ер гардаггүй. Энэ нь юуг харуулж байна гэвэл: “Тахилын судар”-т нарийн тэмдэглэжээ. Чингис хааны тайлга тахилгын үйл ажиллагаа нь Цахар түмнээр гол болгосон Монголын их хааны дэргэд явагдаж байсан гэдгийг харуулж байгаа юм. Мөн онцгойлон цаг хугацааны талаас нь авч хэлбэл Барсболд Жонон Монголын баруун гурван түмэн дэх Чингис хааны найман цагаан ордны тайлга тахилгыг шууд захирахаас өмнөх үйл явдал гэдгийг харуулж байгаа юм. Тиймээс “Тахилын судар”-т “Жонон” гэж гарч ирээгүй бөгөөд харин “Гэрийн ноён” гэх нэн эртний ямдан Чингис хааны тахилгыг эрхлэн явуулж, онцгойлон Монголын их хаан эл зүйлийн тайлга тахилгын ёсыг өөрийн биеэр ёсчлон гүйцэтгэж байсан байна. Дээрхи байдлаас үзвэл “Тахилын судар”-т тэмдэглэсэн Чингис хааны тайлга тахилга бол Ордос дахь Чингисийн найман цагаан ордын тайлга тахилга бүрэлдэхээс өмнөх XV зууны үеийн Монголын Чингис хааны тайлга тахилгын нэгэн бодитой жишээ мөн гэж хэлж болно.

Хоёр. Найман отог Цахар түмнээр гол болгосон нийт Монголын Чингис хааны тайлга тахилгын тухай

“Гэрийн ноён”-ы эрхэлсэн нэгээд эртний үеийн Чингис хааны тайлга тахилгыг Монголын ямар ямар путаг аймгууд голлон гүйцэтгэж байсан бэ? Энэ тухай Чингис хааны тайлга тахилгад хэрэглэх өргөл, тахилгын эд бодисыг

¹³ 那顺乌力吉：《察哈尔万户的起源与形成》，载《内蒙古师范大学学报》哲学社会科学版，2008（5），第55-58页。

¹⁴ 日本 岡田英弘訳注『蒙古源流』，東京刀水書房，2004年10月初版，第234-236頁。

ямар нутаг аймгаас гаргаж байсан байдлыг “Чингис хааны тахилын судар”-т маш тодорхой тэмдэглэсэн байв. Жишээлбэл, Чингис хааны зуны улирлын их тайлга тахилгад эл нутаг аймгаас авч ирэх архи сархадын тоо хэмжээний тухай тэмдэглэлийг үндэслэвэл “Зуны уурын тахил нь, зуны дунд сарын арван таванд тахих. Найман отог Цахар түмнээс морь хонь хоёрыг улирлаар авах. Уураг хургыг “урьдын цагаан сүргийн хүнээс авч ирэх. Наймаас хориод архи авч ирэх. Хоёр гоё нутгаас арван таваад архи авч ирэх. Түүний ялгаа нь бүс нутаг мөн хориод архи авч ирэх. Шувуучин мянганаас дөчин архи авч ирэх. Хоёр гоё нутаг хэмээх нь баруун гараас татаар арван таван архи авч ирэх. Зүүн гараас хэмжээд арван таван архи авч ирэх. Ер бүгд хоёр зуун арван архи байна” гэжээ.

Дээрхи чухал түүхийн сурвалжийн тэмдэглэлийг шинжлэхэд юуны урьд “Зуны уурын тахил нь зуны дунд сарын арван таванд тахих” гэдгийг бид онцгойлон анхаарах хэрэгтэй. Учир нь энд хэлж байгаа нь бол Чингис хааны зуны улирлын их тайлга тахилга гэдэг бол “Зуны уурын тахил” болно. Түүнийг Хятадаар (立夏祭祀) гэж орчуулж болох юм. Энэ нь харин сүүлийн үеийн хүмүүсийн тайлбарлан нэрлэсэн “Зуны уурын их тайлга тахилга” Хятадаар (夏季诺尔大祭) гэдгээс ондоо байна. Миний үзэхээр эрт үедээ “Зуны уурын тахил” гэж байсан боловч монгол бичгийн эртний бичлэгт “Уур” гэдэг үгийг бүр дусалгүйгээр “Ахуур, Агуур” гэж бичиж болдог тул, түүний дуслыг нь сэргээн бичихдээ “Агуур, Уур” гэж буруу уншсан байх боломжтой. Гэвч асуудлын зангилаа нь зөвхөн үг үсгийн алдаа төдий биш, харин цаг хугацааны хувьд авч хэлбэл “Зуны дунд сарын арван таван” гэж тодорхой бичиж байгаа болохоор энэ нь билгийн улирлын “Зуны уур” амьсгалын үе болох юм. Тиймээс чухам “Агуур-у” эсвэл “Нагуур-у” гэдэг асуудлын тухай мөхөс миний бие бас өөр тусгай өгүүлэл бичиж өөрийн үзэл бодлоо өгүүлэх санаатай тул энд дэлгэрүүлэн өгүүлэхээ больё. Дараа нь “Найман отог Цахар түмэн”-ээс Чингис хааны “Зуны уурын тахил”-д морь хонь ба архи сархадын өргөл өргөж байгаа байдал болно. Отог аймгийн бодитой нэрийдэл гэвэл: Найман, Шувуучин мянган, Татаар, Хэмчигүүд зэрэг отгуудын нэрүүд дээрхи материалд гарч ирсэн байв. Эдгээр отог аймгууд нь дээр үед бүр Цахар түмэнд харьяалагдаж байсан бөгөөд “Найман отог Цахар түмэн” гэдэг хэллэг нь ч зөвхөн хэвшсэн хэллэг төдий байж, үнэндээ Цахар түмний харьяат нутгийн тоо нь наймаар хязгаарлагдахгүй юм. Ерөнхийд нь авч хэлбэл дээрхи тэмдэглэл нь түүхэн дээр “Найман отог Цахар түмэн”-ээр голлосон монголчууд Чингис хааны “Зуны уурын тахил” гэж явагдаж байсан гэдгийг гэрчилж байна.

Харин нэн чухал зүйл гэвэл нэлээд эртний үеийн Чингис хааны тайлга тахилгын үйл ажиллагаа нь зөвхөн “Найман отог Цахар түмэн”-д л хязгаарлагдах төдий биш,

харин тухайн үеийн Монголын “Зургаан түмэнээрээ” Чингис хаанаа тайж тахиж байсан явдал болно. Жишээлбэл, “Богд Чингис хааны тахилын судар”-т Чингис хааны тайлга тахилга дээр Монголын их хаанаас “Их түгэл (Хишиг түгээх)” явуулахдаа доорхи мэт тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, тус судрын дөрөвдүгээр хуудсанд: “Түүний хойно их түгэл нь урьд манлайд үг ...түүний хойно таван өнгө улс, зургаан түмэн, Найман отог Цахар тэд бүгдээр ах дүүгээр нь түгээлүг” гэж тодорхой тэмдэглэжээ. Үүнээс үзвэл их хааны “Их түгэл”-ийг заавал “Таван өнгө улс”, “Зургаан түмэн” ба “Найман отог Цахар” түмэнд ах дүүгийн дэс дараагаар нь өгч байсан байна. Онцгойлон энд гардаг “Зургаан түмэн” гэдэг нь яриангүй тухайн үеийн Монголын зүүн гарын Цахар түмэн, Халх түмэн, Урианхай түмэн ба баруун гарын Ордос түмэн, Түмэд түмэн, Ёншөөбу түмнийг зааж байх нь гарцаагүй юм. Өөрөөр хэлбэл, даруй тэр үеийн Чингис хааны тайлга тахилга нь Монголын зургаан түмний нийт Монголын тайлга тахилга байжээ гэдэг нь харагдаж байна.

Товч дүгнэлт

Нэгдүгээрт. Монгол бичгээр бичигдсэн “Богд Чингис хааны тахилын судар оришвой” гэх ховор чухал түүхэн сурвалжийн гэрчилж байхаар аль эрт XV зуунд “Найман отог Цахар түмэн”-ээр голлосон Чингис хааны тайлга тахилга явагдаж байсан бөгөөд тэрчлэн Монголын их хаан өөрийн биеэр тайлга тахилгад оролцон эл зүйлийн тахилгын ёсыг хичээнгүйлэн гүйцэтгэж байсан гэдэг нь сэжиглэшгүй түүхийн үнэн байжээ. Өөрөөр хэлбэл, Ордост Чингис хааны найман цагаан ордны тайлга тахилга бүрэлдэхээс өмнө Цахар түмэнд Монголын их хаан тэргүүтэй “Гэрийн ноён”-ы эрхэлсэн Чингис хааны тайлга тахилга явагдаж байсан байна.

Хоёрдугаарт. XVII зууны үеийн Чингис хааны тайлга тахилга нь хэдийгээр Цахар түмнээр гол болгосон байсан боловч, тэр нь зөвхөн Цахар түмний тахилга төдий биш, харин тухайн үеийн нийт Монголын “Таван өнгө улс” ба Цахар түмэн, Халх түмэн (одоогийн Монгол улсын гол бүрэлдэхүүн), Урианхай түмэн, Ордос түмэн, Түмэд түмэн, Ёншөөбу түмэн гэх “Зургаан түмэн” зэргийг багтаасан нийт Монголын Чингис хааны тайлга тахилга байсан юм.

Гуравдугаарт. “Богд Чингис хааны тахилын судар”-т нарийн тэмдэглэгдсэн түүхэн дээрхи “Гэрийн ноён”-ы эрхэлсэн бас Монголын их хааны биеэр оролцсон Чингис хааны тайлга тахилгын байдал бол 1510 онд Даян хаанаас Барсболдыг Монголын баруун гурван түмний “Жонон”-оор томилж, Чингис хааны найман цагаан ордыг “Жонон”-д шууд тушааж өгөхөөс өмнөх нэлээд эрт үеийн Чингис хааны тайлга тахилгын байдлыг тусгасан ховор нандин мэдээ болох юм. Тэр нь монголчуудаас Чингис хаанаа ямар түүхэн цаг үед ямар отог аймаг буюу аль

нэг түмэн тайж тахиж байсан ч, Чингис хааны тайлга тахилга нь хэзүүд нийт монголчуудын тайлга тахилга байсан гэдгийг харуулж байх бөгөөд одоогийн Ордос дахь Чингис хааны тайлга тахилга ч мөн тийм байна.

Abstract: The Mongols' sacrifice to Genghis khan began when he ascended to heaven. However, there are few records about the sacrifice of Genghis khan in the early period. This paper makes use of the precious historical document "the sacrificial scriptures of the holy Genghis khan", study on the sacrifice of Genghis khan in the history of Mongolia in the 15th century. Among them, the sacrificial ceremony of Genghis khan in *chahar* is not only the sacrificial ceremony in *chahar*. In fact, it was the sacrificial ceremony of all Mongolian at that time, including *khalkh Mongolia*, and the great khan of Mongolia also participated in the sacrificial ceremony of Genghis khan.

Ном зүй

1. 【波斯】拉施特主编，余大钧、周建奇汉译《史集》第一卷第二分册，北京：商务印书馆1983年，第一版第323页。
2. Дорунга (ред.). *Богд Чингис хааны тахилын судар оришвой-Монгол хууч түүхэн номын баглаа*, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1998.
3. Elisabetta Chiodo. "The Book of the Offerings to the Holy Cinggis QaGan: A Mongolian Ritual text" in *Zentralasiatische studien* No.22, 1989/1991, 190-220.
4. Elisabetta Chiodo. "The Book of the Offerings to the Holy Chinggis QaGan: A Mongolian Ritual text (Part 2)" in *Zentralasiatische studien* No.23, 1992/1993, 84-119.
5. N. 胡尔查：《四季祭祀的贡赋及其社会经济基础》（Dörben саг-un qurim-un alba kiged tegün-ü neyigem аju аqui-yin sayuri），《内蒙古社会科学》蒙文版，1988年第4期。
6. Сайнжаргал., Шаралдай. *Алтан ордны тайлага*. Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо. 1883 (анхдугаар хэвлэл).
7. 乌兰：《蒙古源流研究》，沈阳：辽宁民族出版社，2000年，318-319页。
8. 那顺乌力吉：《察哈尔万户的起源与形成》，载《内蒙古师范大学学报》哲学社会科学版，2008（5），第55-58页。
9. [日] 岡田英弘訳注『蒙古源流』，東京刀水書房，2004年10月初版，第234-236頁。
10. Эрдэнэбаатар, М. "Чингис хааны тахилгын давхар сахиусчилагдсан шинж чанар", *Чингис хаан судлал сэтгүүл*-ийн 2010 оны 2 дугаар хугацаа.
11. Erdenebaatar, M. "A Study on the Ritual Scripture of the Holy Cinggis QaGan" in *Mongolica* Vol.21 (42), 2008, 349-355.